



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/552

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цээл сумын засаг даргаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан чөлөөт бөхийн тамирчин Т.Баяржаргалын аймгийн Засаг даргад ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу Тайланд Улсад зохион байгуулагдах Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

